



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРОО**

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон  
Сүхбаатарын талбай 6, Утас: 28-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2023 01 23 № УИХ-04/661


танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ**

"Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай" Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төслийг хэлэлцсэн талаарх Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, хуралдааны тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт <sup>3</sup> хуудастай.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

2023000055



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны тэмдэглэл:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

"Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай" Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төслийг зөвшилцөх.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

"Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай" Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төслийг дэмжиж, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгов.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

БАЙНГЫН ХОРОО  
ХАРИУЦСАН РЕФЕРЕНТ

Б.ГАНДИЙМАА

**“ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ  
ТУХАЙ” МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ КУБА УЛС ХООРОНДЫН  
ГЭРЭЭНИЙ ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 01 дүгээр  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Дээрх гэрээний төслийг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, төслийг дэмжсэн талаарх санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлсэн болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар дээрх төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төслийг зөвшилцөх тухай асуудлыг дэмжсэн болно.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Б.ЭНХ-АМГАЛАН**

**“ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА  
ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ” МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ КУБА УЛС  
ХООРОНДЫН ГЭРЭЭНИЙ ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ ТАЛААР ХУУЛЬ ЗҮЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 01 дүгээр  
сарын 18-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төслийг зөвшилцөх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэгт заасны дагуу Хууль зүйн байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан нар асуулт асууж, хариулт авсан болно.

“Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төслийг зөвшилцөх тухай асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 61.5 хувь нь дэмжсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төслийг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**Ц.МӨНХ-ОРГИЛ**

